

Долоо. Дүүргийн засаг даргын захирамж, Засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу хийж хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлууд:

1. Халиа дошингийн ажил:

Дүүргийн засаг даргын 2024 оны А/462 дугаар захирамжийн дагуу хөрсний болон булгийн ус гадагшилж хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байршлуудад шаардлагатай арга хэмжээ авах ажлын хүрээнд 2025 оны 1, 2, 3 дугаар саруудад **2 хороонд** 1 ховоо машин дайрга асгаж түрж тэгшилсэн, **7 хороонд** 1 ховоо машин дайрга асгаж 3,000 метр газарт суваг татаж, далан босгосон, **9 дүгээр хороонд** 50 метр газар суваг татаж усны урсцыг нэмэгдүүлсэн, **24 дүгээр хороонд** 14 ховоо машин дайрга асгаж, 908 метр газарт суваг татаж, усны урсцыг нэмэгдүүлсэн, **26 дугаар хороонд** 35 ховоо машин дайрга асгаж, 10,870 метр газарт суваг, далан сэргээн татаж, Төгөлдөрийн гүүрний доод талын мөсийг хагалж, усны урсцыг нээсэн, **33 дугаар хороонд** тахилт 27 дугаар гудамжинд хоолой битүүрснийг авч, хавтан тавьсан, **35 дугаар хороонд** 18 ховоо машин дайрга асгаж, 1170 метр газарт суваг татаж, далан босгосон, **40 дүгээр хороонд** 1 ховоо машин дайрга асгаж, 740 метр газарт суваг татаж, сувагчилж голдирол сэргээсэн, **41 дүгээр хороонд** 4 ховоо машин дайрга асгаж, 160 метр газарт суваг татаж, голын голдирол сэргээж ажилласан.



